

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ,  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХӨТӨЛБӨР /2016-2019/-  
ИЙН ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: ТӨА-2020/07/-НА

Зуунмод 2020 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал  
Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер Т.Майцэцэг  
Утас: 70273463 Цахим хаяг: [maitssetseg@audit.gov.mn](mailto:maitssetseg@audit.gov.mn)

Ахлах аудитор Л.Жаргалсайхан  
Утас: 70273465 Цахим хаяг: [jargalsalkhanl@audit.gov.mn](mailto:jargalsalkhanl@audit.gov.mn)

Аудитор Г.Сугармаа  
Утас: 70273465 Цахим хаяг: [sugarmaag@audit.gov.mn](mailto:sugarmaag@audit.gov.mn)



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## АГУУЛГА

<i>Товчилсон үгийн тайлбар</i> .....	3
<i>Аудитын зорилт, хамарсан хүрээ арга зүй, шалгуур үзүүлэлт</i> .....	4-6
<i>Аудит хийх үндэслэл:</i> .....	4
<i>Аудитын зорилт:</i> .....	4
<i>Аудитын хамрах хүрээ:</i> .....	4
<i>Аудитын арга зүй:</i> .....	4
<i>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:</i> .....	4
<i>Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн:</i> .....	5
<i>Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:</i> .....	5
<i>Үндсэн мэдээлэл</i> .....	5
<i>Аудитад гарсан хүндрэл бэрхшээл</i> .....	5-6
<b>БҮЛЭГ 1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн ч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн утга санааг хэд хэд давхцуулж төлөвлөсөн байна.....</b>	7
1.1. Хөтөлбөрийн зарим заалтуудын утга санаа давхцсан байна.....	7-8
1.2. Хөтөлбөр нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаж байна.....	8-9
1.3. Сумдын ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд аймгийн мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр бүрэн тусгагдаагүй, зарим сумд хөтөлбөр, төлөвлөгөөг архивлан хадгалдаггүй байна.....	9-
<b>Error! Bookmark not defined.</b>	
<b>БҮЛЭГ 2. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 22 дугаар тогтоолоор хөтөлбөрийн хэрэгжилтийг 91.00 хувьтай буюу “Үр дүнтэй” гэж дүгнэсэн нь бодит байдалтай нийцэхгүй байна.....</b>	<b>Error! Bookmark not defined.0</b>
2.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2019 онд хөтөлбөрийн I-р зорилтын хүрээнд 5 арга хэмжээг үр дүнтэй, 1 арга хэмжээг тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэсэн нь бодит байдалтай нийцэхгүй байна.....	<b>Error! Bookmark not defined.0-14</b>
2.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2 дугаар зорилтын хүрээнд 5 арга хэмжээг “үр дүнтэй”, 3 арга хэмжээг “тодорхой үр дүнд хүрсэн” биелэлтийн дундаж 88.75 хувь гэж үнэлсэн нь бодитой бус байна.....	14-16
2.3. Мал хулгайлах гэмт хэрэг 2016-2019 онд 76-199 буюу 123 нэгжээр өсөж, хэргийн илрүүлэлт 46.2-37.1 хувь хүртэл буюу 9.1 хувиар, буурсан байна....	<b>Error! Bookmark not defined.</b>

**БҮЛЭГ 3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ-  
үнэлгээ хийхээр төлөвлөсөн ч хэрэгжүүлж ажиллаагүй  
байна.....Error! Bookmark not defined.9**

3.1. Хөтөлбөрийн 9.1-д заасан хугацаанд буюу хагас, бүтэн жилээр хяналт  
шинжилгээ үнэлгээ хийнэ гэсэн заалт хэрэгжээгүй  
байна.....Error! Bookmark not defined.9

3.2. Аймгийн ГХУСАЗСЗ, ЗДТГ-ын ХЭЗХэлтэс хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих  
хяналт хангалтгүй байсан байна.....19-20

3.3. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээнүүд бүрэн хэрэгжсэн гэж үзэх  
боломжгүй байна.....20-21

**ДҮГНЭЛТ.....72**

**ЗӨВЛӨМЖ.....233**

**ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....24**

Төвчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ХШУДАХ	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
МХГХУСАЗДЗ	Мал хулгайлах гэмт хөргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөл
ГХУСАЗСЗ	Гэмт хөргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ХЗХ	Хууль зүйн хэлтэс /тухайн үеийн нэрээр/
ХЭЗХ	Хууль эрх зүйн хэлтэс
ЦГ	Цагдаагийн газар
ХЗС	Хууль зүйн сайд
ХХААС	Хүнс хөдөө аж ахуйн сайд
МХГХТХ	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс
МХГХТДЗ	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх дэд зөвлөл
ХМХГХУСДЗ	Хулгай, мал хулгайлах гэмт хөргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл
МАА	Мал аж ахуй
МХГХУСДЗ	Мал хулгайлах гэмт хөргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл

## Аудитын зорилт, хамарсан хүрээ арга зүй, шалгуур үзүүлэлт

### Аудит хийх үндэслэл:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны аудитын болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, аймгийн ИТХ-ын захиалгаар Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэгт тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

### Аудитын зорилт:

“Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилт”-д аудит хийж, дүнг аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө үндэслэлтэй эсэх
- Хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн эсэх
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ үр дүнтэй эсэх

### Аудитын хамрах хүрээ:

Аудитаар Аймгийн ИТХ, ГХУСАЗСЗ, ХЗХ, ЦГ, Хүнс хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, сумдын ГХУСАЗСЗ болон Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх дэд зөвлөлийн 2016-2019 оны мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд гарсан шийдвэр, бодлого, түүний хэрэгжилтийг хамруулсан.

### Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтантай уулзалт, ярилцлага зохион байгуулах, тэдгээрийн өгсөн тайлан, судалгааг тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан болно. Аудитын дүн дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

### Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглалаа. Үүнд:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль,
2. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль,
3. Малын генетик нөөцийн тухай хууль,
4. Малын эрүүл мэндийн тухай хууль,
5. Эрүүгийн хууль,
6. Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль,
7. Зөрчлийн тухай хууль,

8. Зөрчлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль,
9. Журам шинэчлэн батлах тухай /малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох/ МҮЗГ-ын тогтоол /2013, 2019/;
- 10.Х3Сайд, ХХААС-ын 2016 оны А/160А/73- дугаар “Малчдын бүлэг ажиллуулах үлгэрчилсэн дүрэм”,
- 11.Аймгийн ИТХ-ын тогтоол,
- 12.Аймгийн Засаг даргын захирамж,
- 13.ГХУСАЗСЗ-ын тогтоол

### **Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн:**

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Т.Майцэцэг удирдан, ахлах аудитор Л.Жаргалсайхан аудитор Г.Сугармаа нар 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 26-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

### **Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:**

Аудитын ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн.

### **Үндсэн мэдээлэл**

Аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоо арга хэмжээг зохион байгуулах, малын хариулга, маллагааг сайжруулах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, орчин үеийн дэвшилтэд техник технологийг ашиглах замаар мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, малчид, төрийн болон төрийн бус байгууллагуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 92 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тогтоолоор мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр /2016-2019/-ийг баталж, 3 зорилтын хүрээнд жил бүр тусгай төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулахаар тусгасан байна.

2017 оны 06 дугаар сард “хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг дүгнэх тухай тогтоол баталж, “тодорхой үр дүнд хүрсэн” хэмээн дүгнэсэн 2018 оны 11 дүгээр сард уг хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай тогтоолыг батлан уг тогтоолуудаар аймаг, сумын Засаг дарга наарт тус тус чиглэл өгөгджээ.

Мөн түүнчлэн 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 22 дугаар “Хөтөлбөрийн хэрэгжилт дүгнэж, төлөвлөгөө батлах тухай” тогтоолоор тус хөтөлбөрийн хэрэгжилтийг 91 хувьтай байгаа тул “үр дүнтэй” гэж дүгнэн, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө /2020-2022/-г баталсан байна.

### **Аудитад гарсан хүндрэл бэрхшээл**

Дэлхий дахинд COVID-19 буюу шинэ төрлийн короновирусийн халдвар тархсантай холбогдуулан “мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр /2016-2019/-ийн хэрэгжилт” нийцлийн аудитыг гүйцэтгэх явцад Монгол Улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/80 дугаар тушаалаар батлагдсан “Зөвлөмж”-ийг баримтлан зөвхөн нэн шаардлагатай албан хаагчтай уулзалт хийж, шаардлагтай баримтуудыг файлаар нь авч онлайн хэлбэрээр аудит хийгдсэн.

2016-2019 оныг хамруулан аудит хийхэд сумдын уг хөтөлбөрийг хариуцсан албан хаагчид ажлаас чөлөөлөгдөн солигдож өмнөх оны баримт материалыг хүлээлцээгүй, архивлан хадгалаагүйгээс онлайнаар ирүүлсэн баримт болон байгууллагуудын цаасаар ирүүлсэн баримт, материалын хүрээнд аудит хийгдлээ.

**Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн ч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн утга санааг давхцуулж төлөвлөсөн байна.**

### **1.1. Хөтөлбөрийн зарим заалтуудын утга санаа давхцсан байна.**

Төв аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 92 дугаар тогтоолоор 2016-2019 онд хэрэгжүүлэхээр “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх” хөтөлбөр /цаашид хөтөлбөр гэх/-ийг баталсан.

Уг хөтөлбөрийн хүрээнд “Харьяа нутаг дэвсгэртээ мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авах”, “Малыг улсын хэмжээний индексжүүлэлт, им тамга тэмдгийн сүлжээнд бүрэн хамруулах зохион байгуулалтын арга хэмжээг авах, иргэд, малчдын оролцоог нэмэгдүүлэх, мал туварлалт, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний тээвэрлэлт, борлуулалт, нийлүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх”, “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажилд техник технологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэн ашиглах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж байгаа цагдаагийн газар, алба хаагчдыг шаардлагатай техник бусад тусгай хэрэгслээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, хууль хяналтын байгууллагатай хамтран цаг үеийн нөхцөл байдалд уялдуулан хяналт шалгалтыг зохион байгуулах” гэсэн 3 зорилт 20 арга хэмжээтэй баталж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ жил бүр тусгай төлөвлөгөө боловсруулан зохион байгуулахаар төлөвлөжээ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

- Аймгийн Засаг даргын 2016 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/113 дугаар захирамжаар “удирдлага зохион байгуулалт”, “сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа” болон “хууль хяналтын хүрээ”-нд нийт 20 арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр баталсан байна.
- 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/183 дугаар захирамжаар 2017-2018 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 1-р зорилтын хүрээнд 15 арга хэмжээ, 2-р зорилтын хүрээнд 8 арга хэмжээ, 9 арга хэмжээ нийт 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.
- 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулаагүй байна.

Зарим хөтөлбөрийн заалт болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь утга санааны хувьд давхардсан байдлаар томьёологдож батлагдсан байна. Аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн 2017 оны 06 дугаар сарын 27-нд хөтөлбөрт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд мөн утга санаанууд давхацсан гэж тусгагдаж байсан байна.

Хөтөлбөрийн:

7.1.6. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд Цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах,

7.3.1. Аймгийн Цагдаагийн газрын МХГХТХ болон сумдын хэсгийн төлөөлөгч нарыг нэн шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах дэмжлэг үзүүлэх,

7.3.6. Сумдын хэсгийн төлөөлөгчдийн үйл ажиллагаанд гэмт хэрэг илрүүлэх, шалгах, орон нутгийн захирагааны байгууллагаас дэмжлэг үзүүлэх гэсэн 3 заалт,

7.2.6. Орон нутгаас бэлтгэсэн мал, мах, түүхий эдийг тухайн сумын мал эмнэлгээс олгосон ариун цэвэр, гарал үүслийн бичиг, баг, сумын Засаг даргын тодорхойлолт зэргийг үндэслэн төв суурин газарт оруулж байх журам зааврыг мөрдүүлж хэвшүүлэх түүнд тавих хяналтыг сайжруулах,

7.2.7 Мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээг олгож, хяналт тавьж байгаа багийн Засаг дарга, улсын байцаагч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарын хариуцлагыг өндөржүүлж, гэрчилгээгүй мах, түүхий эд бэлтгэх, худалдах, туварлуулахгүй байх нөхцөлийг хангаж ажиллах гэсэн 2 заалт тус тус хоорондоо утга санаа давхацсан.

Хөтөлбөрийг 2017-2018 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний:

8.1 “Мал махны үйлдвэрлэл, худалдаа эрхэлж байгаа иргэд, ААН-ийн үйл ажиллагаа, амьд мал болон махны гарал үүслийн гэрчилгээний олголт, баталгаажилт, малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулна,

10.1 “Мал, махны үйлдвэрлэл, худалдаа эрхэлж байгаа иргэд, ААН-ийн үйл ажиллагаа, гарал үүслийн гэрчилгээний олголтод хяналт шалгалт хийнэ гэх заалтуудын утга санаа мөн давхацсан байна.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө нь шалгуур үзүүлэлттэй, 2017-2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө нь шалгуур үзүүлэлтгүй батлагдсан нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 “Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг оновчтой бодлогын хувилбарт үндэслэн зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөж боловсруулна” гэсэнтэй нийцэхгүй байна.

## 1.2. Хөтөлбөр нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаж байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн II-р хуралдааны 01 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын “Үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний /2016-2020 он/ төлөвлөгөөг батлах тухай” баталсан. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 6.18.54-т “Мал хулгайлах гэмт хэргийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 жилээр гарган хэрэгжилтэд хяналт тавина” гэж тусгажээ. Мөн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2017 онд “Мал хулгайлах гэмт хэргийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ, малчдын бүлэг нөхөрлөлийг ажиллуулах журмыг хэрэгжүүлэх, нөхцөлийг сайжруулах, мэдээлэл харилцаа холбоог сайжруулна” /6.22-д/ гэж, 2018 онд “Мал хулгайлах гэмт хэргийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, энэ чиглэлээр “нэгдсэн” болон “хэсэгчилсэн” арга хэмжээ зохион байгуулна” /6.3.23-д/ гэж, 2019 онд “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг эрчимжүүлнэ” /6.3.17.34-д/ гэж тус тус тусгасан байна.

Эндээс үзэхэд Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдсан байна.

Харин хөтөлбөрийн “5.3-д Аймаг сумд хөтөлбөрийн хэрэгжүүлэхдээ жил бүр тусгай төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана”, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 6.18.54-т “Мал хулгайлах гэмт хэргийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 жилээр гарган хэрэгжилтэд хяналт тавина” гэж тусгасан боловч 2019 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлаагүй байна.

**1.3. Сумдын ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд аймгийн мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр бүрэн тусгагдаагүй, зарим сумд хөтөлбөр, төлөвлөгөөг архивлан хадгалдаггүй байна.**

Төв аймаг дахь Төрийн аудитын газраас 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдөр сумын ГХУСАЗСЗ-д дээрх хөтөлбөрийн дагуу 2016-2019 онуудад хийгдсэн хөтөлбөрийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлэхэд 27 сумаас 19 сум хариу ирүүлсэн бөгөөд Аргалант, Батсүмбэр, Бүрэн, Мөнгөнморьт, Зуунмод, Сэргэлэн, Сүмбэр, Угтаалцайдам сумд хариу ирүүлээгүй.

Хариу ирүүлсэн 19 сумаас хөтөлбөрийн төлөвлөгөөг ирүүлсэн байдал:

- Архуст сумын МХГХУСАЗДЗ нь 2017 онд 9, 2019 онд 8 заалт бүхий ажлын төлөвлөгөөг,
- Баяндэлгэр сум 2017 онд 8 заалт бүхий “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө /2017-2019/-г,
- Баян-Өнжүүл сумын МХГХТЗ нь 2017 онд 7, 2018 онд 8, 2019 оны I, II-р улиралд 5, III, IV -р улиралд 6 заалт бүхий ажлын төлөвлөгөөг,
- Баянхангай сумын ХМХГХУСДЗ нь 2018 онд 7, 2019 онд 8 заалт бүхий ажлын төлөвлөгөөг,
- Баянчандмань сумын ИТХ-ын тэргүүлэгчид 2017 онд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх аймгийн хөтөлбөрийн 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг,
- Борнуур сумын МХГХУСДЗ нь 2017 онд 11 заалт бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг,
- Дэлгэрхаан сум нь хөтөлбөрийн 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг,
- Жаргалант сумын ГХУСАЗСЗ-ийн 2018 оны төлөвлөгөөнд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх дэд зөвлөлийн хүрээнд 7, МХГХТДЗ-ийн 2019 онд 8 хэрэгжүүлэх арга хэмжээ бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг,
- Заамар сумын ГХУСАЗСЗ-н 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд МХГХТДЗ-ийн үйл ажиллагааны хүрээнд 5, 2017 онд 7, 2018 онд 4 заалт бүхий төлөвлөгөөг,
- Лүн сумын ГХУСАЗСЗ-ийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5, 2018 онд 14, 2019 онд 10 заалт бүхий төлөвлөгөөг тус тус баталжээ.

Баянцагаан, Баянжаргалан, Баянцогт, Өндөрширээт, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант сумд хөтөлбөрийн хэрэгжилт, биелэлтийг гаргасан хэдий ч 2016-2019 оны төлөвлөгөөг ирүүлээгүй.

Алтанбулаг, Дэлгэрхаан сумд хөтөлбөрийг хариуцдаг албан тушаалтан үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн учир 2016-2018 оны хөтөлбөрийн төлөвлөгөө, хэрэгжилт байхгүй, Баян сум “Тус сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хулгай, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл нь 2016-2019 онд хэрэгжих мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг сумандaa хэрэгжүүлсэн боловч нотлох баримт нь архивд тушаагдаагүй, файл нь устгагдсан гэх тайлбарыг сумын хэсгийн төлөөлөгч өгсөн тул холбогдох бичиг баримт явуулах боломжгүй” тухай албан бичгээр тус тус мэдэгдсэн.

Хөтөлбөрийн 5.3-т “Аймаг, сумд хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ жил бүр тусгай төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана” гэж тусгасан боловч бүрэн хэрэгжээгүй, зарим сумд ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох заалтыг тусгаж байгаа ч хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг бүрэн тусгасан гэж үзэх боломжгүй байна.

**БҮЛЭГ 2.** **Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 22 дугаар тогтоолоор хөтөлбөрийн хэрэгжилтийг 91.00 хувьтай буюу “Үр дүнтэй” гэж дүгнэсэн нь бодит байдалтай нийцэхгүй байна.**

**2.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2019 онд хөтөлбөрийн I-р зорилтын хүрээнд 5 арга хэмжээг үр дүнтэй, 1 арга хэмжээг тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэсэн нь бодит байдалтай нийцэхгүй байна.**

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр нь үндсэн З зорилттой бөгөөд 1 дүгээр зорилт нь “Харьяа нутаг дэвсгэртээ мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх, иргэд болон малчдын бүлгийн оролцоог нэмэгдүүлэх, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авах” гэж батлагдсан.

Хөтөлбөрийн 9.2-т “Сумдын ГХУСАЗСЗ, холбогдох агентлагууд хөтөлбөрийн биелэлтийг аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэст хагас, бүтэн жилээр гаргаж ирүүлнэ” гэж тусгагдсан. Гэвч хөтөлбөрийн биелэлтийг дээрх хугацаанд гаргаж ирүүлж байгаагүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс 2016, 2017 оны хагас жилээр буюу 6 дугаар сард, 2018 оны 10 дугаар сард, 2019 онд хагас бүтэн жилээр хэрэгжилтийг гаргасан байна. Хөтөлбөр хэрэгжсэн 4 жилд хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр хэрэгжилтийг гаргаж дүгнээгүй тул харьцуулж дүгнэх боломжгүй байна. Аймгийн ИТХТ-ийн 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 22 дугаар тогтоолоор хөтөлбөрийн хэрэгжилтийг 4 жилээр дүгнэж, баталгаажуулсан хэрэгжилтийг /аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ 2019 оны 12 дугаар сарын 23-нд хэрэгжилтийг гаргасан/ аудитад шалгур болгон авч үзлээ. Энэхүү гаргасан хэрэгжилтээр хөтөлбөр 4 жил хэрэгжээд 91 хувийн биелэлтэй гэж дүгнэжээ.

Хөтөлбөрийн 5.3-д аймаг, сумд хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ жил бүр тусгай төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулна гэсний дагуу аймгийн Засаг даргын 2016 оны А/113 тоот захирамжаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2016 оны төлөвлөгөө, 2017 оны А/183 тоот захирамжаар 2017-2018 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнүүд тус тус батлагдсан.

#### Хүснэгт 1: Хөтөлбөрийн 2019 оны хэрэгжилт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлтийн хувь
1.1.	Холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх, аймаг, сумын ГХУСАЗСЗ-ийн ажлын тайлан, сонсгал мэдээллийг аймаг, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн үр дүнг тооцно.	70%
1.2.	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр аймаг, сумдын Гэмт хөргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулна.	100%
1.3.	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	100%
1.4.	Аймаг, сумдад мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх санг байгуулах, мал сүрэг хамгаалах малчдын бүлэг, холбоо нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах асуудлыг шийдвэрлэнэ.	100%
1.5.	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд иргэд, Төрийн болон Төрийн бус байгууллагыг татан оролцуулна.	100%
1.6.	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд Цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллас	100%

Эх сурвалж: ХЭЗХ, МХГХТУСХ-ийн хэрэгжилтийн төвчоо 2019.12.23

Хөтөлбөрийн I-р зорилтын 6 арга хэмжээний биелэлтийн дундаж нь 95 хувь гэж үнэлсэн байна. 1 дүгээр зорилтын хэрэгжүүлэх 6 арга хэмжээнээс 1.2, 1.4-д заагдсан арга хэмжээнүүдийн хүрээнд тодорхой ажлууд хийгдэж үр дүн гарсан байна.

Хөтөлбөрийн 1 дүгээр зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний 1.2 дахь заалтын хүрээнд Сумдын ГХУСАЗСЗ болон дэд зөвлөлүүдийн ажлыг жил бүр аймгийн ГХУСАЗСЗ-ийн даргын баталсан 12 үзүүлэлтийн 24 хэрэгжүүлэх арга хэмжээ бүхий шалгуур үзүүлэлтээр дүгнэдэг болсон байна. 2016 онд сумдын салбар зөвлөлүүд маш хангалтгүй, оноо эзлүүлэх боломжгүй, дунджаар 69.02 хувьтай дүгнэгдэж байсан бол 2017 онд 71.5 хувьтай, 2018 онд 81.5 хувьтай, 2019 оны эхний хагас жилийн байдлаар 83.81 хувьтай, аймгийн хэмжээнд гэмт хөргээс урьдчилан сэргийлэх ажил 84.80 хувьтай дүгнэгджээ.

#### Хүснэгт 2 Сумдын ГХУСАЗСЗ болон МХГХТДЗ-ыг шинэчлэн баталсан байдал

№	Сумын нэр	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх дэд зөвлөл		
		Огноо, тогтоолын дугаар	Дарга	Гишүүдийн тоо
1	Алтанбулаг	2014.04.01 №21	Сумын засаг дарга	6
2	Архуст	2017.02.09 №13	Сумын засаг дарга	5
3	Баян	2019.03.15 №12	Сумын засаг дарга	8
4	Баянжаргалан	2019.02.15 №01	Мал эмнэлэг үргжлийн тасгийн мэргэжилтэн	5
5	Баян-Өнжүүл	2017.03.16 №13	Засаг даргын орлогч	4
6	Баянхангай	2017.03.30 №24	Сумын засаг дарга	5
7	Баянцагаан	2017.02.17 №17	Сумын засаг дарга	8
8	Баянцогт	2017.02.23 №15	Сумын засаг дарга	5
9	Баянчандмань	2017.02.09 №03	Сумын засаг дарга	6
10	Борнуур	2018.03.16 №19	Сумын ИТХ-ын дарга	31
11	Дэлгэрхаан	2019.01.22 №01	Сумын хэсгийн төлөөлөгч	7
12	Заамар	2019.03.19 №11	Сумын засаг дарга	7
13	Лүн	2017.03.20 №19	Сумын засаг дарга	6

14	Эрдэнэ	2017.02.10 №26	Сумын засаг дарга	10
15	Эрдэнэсант	2017.02.27 №24	Сумын засаг дарга	6

Эх сурвалж: Сумдын ИТХТ-н тогтоол, ГХУСАЗС3-н тогтоолууд

Хөтөлбөрийн 1 дүгээр зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний 1.4 дэх заалтын хүрээнд аймгийн ГХУСАЗС3-ийн хуралдааны 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 07 дугаар тогтоолоор “Малчдын бүлгийн ажиллах журам”-ыг баталж, малчдын бүлгийн үйл ажиллагааг ерөнхий удирдлага зохион байгуулалтаар хангаж, тэдний ажлын үр дүн, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцон дүгнэж, аймгийн гэмт хөргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд ирүүлж ажиллахыг сумдын ГХУСАЗС3-ийн дарга наарт үүрэг болгосон байна.

2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар Төв аймгийн 18 суманд 84 малчдын бүлэг бүртгэлтэй байна. Үйл ажиллагаагаа тогтвортой явуулдаг 65 малчдын бүлгээс үйл ажиллагааг явуулах эрхийг 2017 онд авсан Лүн сумын “Сонин хангай” малчдын бүлэг хамгийн олон буюу 112 гишүүнтэй, Баянчандмань сумын 2009 онд эрх авсан “Их үйлс”, Борнуур сумын 2018 онд эрх авсан “Найман зуун булаг”, Баянцогт сумын 2017 онд эрх авсан “Агът”, Өндөрширээт сумын 2018 онд эрх авсан “Сант” малчдын бүлгүүд үйл ажиллагаагаа тогтвортой явуулдаг, хамгийн цөөн буюу тус тус 7 гишүүнтэй байна. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд буюу 2016 оноос хойш 63 малчдын бүлэг байгуулагдсан байна.

#### Хүснэгт 3: Төв аймгийн малчдын бүлгийн судалгаа

№	Сумын нэр	Малчдын бүлгийн	Сум дүүргийн ГХУСАЗС3-өөс үйл ажиллагаа явуулах эрх олгосон хугацаа									Тогтвортой үйл ажиллагаа явуулдаг эсэх	
			Харьяа баг	тоо	2015 оноос өмнө	2016	2017	2018	2019	2020	Тийм	Үгүй	
1	Алтанбулаг	1, 2	9				7		2	6	3		
2	Аргалант	2, 4	6				6				6		
3	Архуст	1, 2	4	4							4		
4	Баянчандмань	3	8	8							2	6	
5	Борнуур	1, 2, 4	12				12				12		
6	Баян	2	1				1				1		
7	Баянцогт	1, 2	2			2					2		
8	Баяндэлгэр	1, 2	5			2	3				5		
9	Баянжаргалан	1	1	1							1		
10	Баянхангай	2	2				2				2		
11	Үгтаалцайдам	2	2	2							2		
12	Жаргалант	2, 3, 4	3				3				3		
13	Лүн	1, 2	3	1		1	1				3		
14	Сүмбэр	1, 2, 4	8			8					8		
15	Сэргэлэн	2	2			2					2		
16	Өндөрширээт	1, 2, 3	8				8				8		
17	Эрдэнэ	1, 3	3			3					1	2	
18	Эрдэнэсант	1, 2, 4	5	5							1	4	
<b>Нийт</b>		<b>35</b>	<b>84</b>	<b>21</b>	<b>2</b>	<b>19</b>	<b>40</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>65</b>	<b>19</b>		

Эх сурвалж: Төв аймгийн ГХУСАЗС3

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэд, малчдын идэвх санаачилгыг өрнүүлэх, мал сүргийг хамгаалах арга ажиллагаа, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Тэргүүний мал хамгаалах малчдын бүлгийг 2017, 2019 онуудад тус тус шалгаруулж шагнасан байна.

Харин хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний зарим заалт дутуу болон огт хэрэгжээгүй байхад хэрэгжилтийг 70-100 хувтайг гэж дүгнэсэн байна. Тухайлбал:

Хөтөлбөрийн 1 дүгээр зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний 1.1-д холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх, аймаг, сумын ГХУСАЗСЗ-ийн ажлын тайлан, сонсгал мэдээллийг аймаг сумдыг ИТХ-аар хэлэлцүүлэн үр дүнг тооцно гэж тусгагдсан.

Хэрэгжилтийг гаргахдаа “хөтөлбөрийн хэрэгжилтийг 4 удаа буюу хөтөлбөр хэрэгжсэн жил тутамд ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж, холбогдох үүрэг чиглэлийг авч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн 27 сумын ГХУСАЗСЗ-ийн дэргэд ажиллах “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-ийн хүрээнд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг сум орон нутгийн хэмжээнд тооцож, жилд 1-ээс доошгүй удаа сумын Засаг даргын Зөвлөл болон ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж ажиллаж байгаа бөгөөд 2019 онд хөтөлбөрийн хэрэгжилт сум, байгууллагын дунджаар 80.0 хувтайг буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнээд байна” гээд хэрэгжилт 70 хувтайг гэж дүгнэжээ.

Гэтэл хөтөлбөрт заасны дагуу сумын ГХУСАЗСЗ, холбогдох агентлагууд хөтөлбөрийн биелэлтийг хөтөлбөр хэрэгжих 4 жилийн хугацаанд аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-т хагас, бүтэн жилээр гаргаж ирүүлээгүй, хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй байна. Биелэлт гаргахдаа ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд 4 удаа хэлэлцүүлсэн гэсэн боловч 3 удаа хэлэлцүүлсэн, 2019 онд аймгийн ГХУСАЗСЗ-н хуралд хэлэлцүүлсэн байна. ИТХТ, Засаг даргын зөвлөл, ГХУСАЗСЗ-н хуралд хагас жилээр гаргасан хэрэгжилтийг хэлэлцүүлжээ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2016 онд сумын ИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн сум байхгүй. Баян, Баянжаргалан, Баянхангай, Баянцагаан, Заамар, Өндөрширээт сумд 2016-2019 онд хөтөлбөрийн хэрэгжилтийг сумын ИТХТ-ын хурлаар хэлэлцүүлээгүй. Баянцогт, Цээл, Эрдэнэ сумд аудитын хугацаанд 2020 оны 4, 5 дугаар сард сумын ИТХТ-н хурлаар хэлэлцүүлсэн байхад хэрэгжилтийг 70 хувтайг гэж дүгнэсэн нь бодитой бус байна.

Хүснэгт 4 Аймаг, сумын ИТХТ-ийн хурлаар хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэсэн байдал

№	Сумын нэр	2017 он / дугаар	Дүн	2018 он / дугаар	Дүн	2019 он / дугаар	Дүн	2020 он / дун дугаар
1	Алтанбулаг					2019.10.1 8 №66	Үр дүнтэй	
2	Архуст			2018.12.1 9 №70	90.7%	2019.12.0 5 №89	85%	
3	Баян				Дүгнээгүй			
4	Баяндэлгэр					2019.12.1 6 №A/66	Үр дүнтэй	
5	Баянжаргалан				Дүгнээгүй			
6	Баян-Өнжүүл			2018.05.2 9 №61	86%	2019.06.1 5 №38	70%	
7	Баянхангай				Дүгнээгүй			
8	Баянцагаан				Дүгнээгүй			
9	Баянцогт							2020.04.27 №14
10	Баянчандмань	2017.06.1 4 №32	86%			2019.09.2 5 №50	80%	
11	Борнуур					2019.07.2 3 №59	82.85%	
12	Дэлгэрхаан					2019.11.2 2 №35	93.5%	

13	Жаргалант		2018.01.3 1 №10	77.60%	2019.01.3 1 №11	92.60%		
14	Заамар			Дүгнээгүй				
15	Зуунмод							
16	Лүн		2018.06.2 0 №28	86.90%	2019.10.2 5 №44	Тодорхой үр дүнд хүрсэн		
17	Өндөрширээт			Дүгнээгүй				
18	Цээл					2020.05.2 7 №44	89.1%	
19	Эрдэнэ	2017.10. 11 №94				2020.05.1 4 №45		
20	Эрдэнэсант		2018.06.2 1 №31	61.6%	2019.10.1 5	83.3%		
21	Аймаг	2017.06.2 9 №76	61% 6 №94	Эрчим- жүүлэх		2020.03.12 №22	91%	

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ийн тэргүүлэгчдийн тогтоол

Хөтөлбөрийн 1 дүгээр зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний 1.4-д аймаг, сумдад мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх санг байгуулах гэж тусгагдсан боловч сан байгуулаагүй байхад энэ арга хэмжээг 100 хувь хэрэгжсэн гэж дүгнэжээ.

ИТХТ-ийн 2020 оны 22 дугаар тогтоолоор хөтөлбөрийн I-р зорилтын 1.1, 1.4 дэх заалтууд нь бүрэн хэрэгжээгүй байхад 5 арга хэмжээг үр дүнтэй, 1 арга хэмжээг тодорхой үр дүнд хүрсэн, биелэлтийн дундаж 95.00 хувь гэж үнэлсэн нь бодитой бус байна.

## 2.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2 дугаар зорилтын хүрээнд 5 арга хэмжээг “үр дүнтэй”, 3 арга хэмжээг “тодорхой үр дүнд хүрсэн” биелэлтийн дундаж 88.75 хувь гэж үнэлсэн нь бодитой бус байна.

Хөтөлбөрийн 2 дугаар зорилтыг “Малыг улсын хэмжээний индексжүүлэлт, им тамга тэмдгийн сүлжээнд бүрэн хамруулах зохион байгуулалтын арга хэмжээг авах, иргэд малчдын оролцоог нэмэгдүүлэх, мал тууварлалт, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний тээвэрлэлт, борлуулалт, нийлүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх” гэж тодорхойлсон.

Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийн дунджийг 88.75 хувь гэж дүгнэсэн байна.

Хүснэгт 5: Хөтөлбөрийн 2019 оны хэрэгжилт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлтийн хувь
2.1.	Төв суурин газарт төвлөрсөн мал, махны зах, нядалгааны цэг ажиллуулах асуудлыг шийдвэрлэх	70%
2.2.	Мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрсдийн эзэмшилд байгаа малаа бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүрэн хамруулахад Төрийн байгууллагатай хамтран ажиллах	100%
2.3.	Мал бүхий иргэд малаа им тэмдэг, зүсмийн бүртгэлд оруулах бод малаа улсын хэмжээний индексжүүлэлт, им тамга тэмдгийн сүлжээнд бүрэн хамруулсан байх	70%
2.4.	Байгаль цаг уурын байдлаас шалтгаалан мал бүхий иргэд, малчдын мал сүргээ оторлох, тууварлах, шилжин суурьших хөдөлгөөн хийх үед тухайн орон нутгийн мал эмнэлэг, үржлийн тасаг нь мал эмнэлэг ариун цэврийн гарал үүслийг тодорхойлох, гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулах	100%

2.5.	Сум, багийн Засаг дарга, ЗДТГ-аас мэдээлэл холбооны байгууллагуудтай хамтран тууврын зам, гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй газар нутгийн байршилыг тогтоох, багийн холбооны сүлжээг ажиллуулах, мал хулгайлалыг гэмт хэрэг гарсан үед шуурхай мэдээлэл солилцох нөхцөлийг хангаж ажиллах	100%
2.6.	Орон нутгаас бэлтгэсэн мал, мах, түүхий эдийг тухайн сумын мал эмнэлгээс олгосон ариун цэвэр, гарал үүслийн бичиг, баг, сумын Засаг даргын тодорхойлолт зэргийг үндэслэн төв суурин газарт оруулж байх журам зааврыг мөрдүүлж хэвшүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах	70%
2.7.	Мал эмнэлэг ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээг олгож, хяналт тавьж байгаа багийн Засаг дарга, улсын байцаагч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарын хариуцлагыг өндөржүүлж, гэрчилгээгүй мах, түүхий эд бэлтгэх, худалдах тууварлуулахгүй байх нөхцөлийг хангаж ажиллах	100%
2.8.	Мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг, шинжилгээг тогтмолжуулах, мал махны гарал үүсэлд хяналт тавих, мал амьтан, мах, түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдах, тээвэрлэх, тууварлуулахгүй байх арга хэмжээг авах	100%

Эх сурвалж: ХЭЗХ, МХГХТУСХ-ийн хэрэгжилтийн товчоо 2019.12.23

Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын 2.1-д заасан арга хэмжээний хүрээнд тодорхой ажлууд хийгдсэн байна. Аймгийн хэмжээнд мах төхөөрөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Эрдэнэ хүнс САМО” ХХК, “Эко пүүдс” ХХК, “Баяндэлгэр хүнс” ХХК, “Урьхан” ХХК-ийн Зуунmod мах боловсруулах үйлдвэр гэх 4 үйлдвэр, Тээг хангай хоршооны мал нядалгааны цех, Хустайн мандал хоршооны мал нядалгааны цех, Мал нядалгааны цех /Д.Түвшинжаргал/, Лүн мал нядалгааны цех гэх 4 цех бүртгэлтэй байна. Эрдэнэ хүнс ХХК нь 58 ажилтантай, Баяндэлгэр хүнс ХХК 15 ажилтантай, Зуунmod мах боловсруулах үйлдвэр, Тээг хангай хоршоо, Хустайн мандал хоршоо, Эко фүүдс ХХК, Эрдэнэсант сумын нядалгааны цех, Лүн сумын нядалгааны цех, Сэргэлэн сумын хээрийн бой тус тус 1 ажилтантай гэх судалгааг 2019 онд гаргасан байна.

#### Хүснэгт 6: Төв аймгийн мах боловсруулах үйлдвэрийн судалгаа

№	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил, хаяг	Агуулахын багтаа мж, тн	Суурилагдсан хүчин чадал	Үйл ажиллагаа явуулж байгаа байдал	Тайлбар
1	“Эрдэнэ Хүнс” ХХК	Эрдэнэ сум 1-р баг үйлдвэрийн байр,	1000	1 ээлжинд 10 тн мах ангилан савлаж, 3 тн мах дулааны аргаар боловсруулах	2010 оноос хойш үучилсэн үйл ажиллагаатай	мах боловсруулах, төхөөрөх үйлдвэр хавсарсан.
2	“Баяндэлгэр Хүнс” ХХК	Баяндэлгэр сум, 1-р баг,	190	Жилдээ 150 тн мах ангилан савлах	2016. оны 4-р сараас хойш тогтмол үйл ажиллагаатай	мах боловсруулах, төхөөрөх үйлдвэр хавсарсан.
3	Урьхан ХХК-ний “Зуунmod мах боловсруулах” үйлдвэр	Зуунmod 4-р баг,	60	1 ээлжинд 3 тн мах болон дайвар бүтээгдэхүүн ангилан савлах	2011 оноос хойш үучилсэн үйл ажиллагаатай	мах боловсруулах, төхөөрөх үйлдвэр хавсарсан.

Эх сурвалж: ХХААГ, YXYАлба

Хөтөлбөрийн 2 дугаар зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний 2.2, 2.3 дахь заалт нь мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллага өөрсдийн эзэмшилд байгаа малаа бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүрэн хамруулах, им тамга тэмдгийн сүлжээнд бүрэн хамруулсан байх гэсэн ойролцоо утга агуулга бүхий заалтууд байна. Хэрэгжилтийг гаргахдаа Малын генетик нөөцийн тухай хууль, Малын эрүүл мэндийн

тухай хуулиуд шинэчлэгдсэнтэй хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан малын удам зүйн бүртгэл нэгдсэн программ улсын хэмжээнд боловсруулагдах, программын шинэчлэлийн ажил үргэлжлэн явагдаж байна гээд хэрэгжилт 70-100 хувь гэж дүгнэжээ.

Хариуцсан байгууллага болох аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан бичиг, холбогдох мэргэжилтнээс “...малын удам зүйн үнэлгээний программ хангамжийг ашиглалтад оруулах ажлын хүрээнд 2018, 2019 онуудад ашиглах боломжгүй байсан, хээлтэгч малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх ажлын хүрээнд 24,255 толгой үржлийн малыг ялган тэмдэглэж бүртгэл мэдээллийн санд оруулахаар ХХААХҮЯ-тай гэрээ байгуулсан, дээрх тооны малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх ажлыг орон нутагтаа зохион байгуулж ажилласан бөгөөд бүртгэлийн мэдээллийн санд оруулах ажил бүртгэлийн программ хангамжийг татан суулгах техник тоног төхөөрөмжийн шаардлага хангахгүй байгаагаас хүлээгдээд байна...” гэсэн тайлбарыг ирүүлсэн.

Эндээс үзэхэд нэгдсэн мэдээллийн сан, бүртгэл мэдээллийн программ хангамж ашиглах ажил хийгдээгүй, 24255 толгой үржлийн малыг ялган тэмдэглэж бүртгэл мэдээллийн санд оруулахаар ХХААХҮЯ-тай гэрээ байгуулсан нь аймгийн статистик мэдээгээр сүүлийн 4 жилийн хээлтэгч малын дунджийн /2301453 толгой/ 1.05 хувийг эзэлж байна. Гэтэл хөтөлбөрийн 2 дугаар зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний 2.2-г 100 хувь, 2.3-г 70 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэсэн нь бодит байдалд нийцэхгүй байна.

Аймгийн ИТХТ-ийн 2020 оны 22 дугаар тогтоолоор хөтөлбөрийн хэрэгжилтийг 2 дугаар зорилтын хүрээнд 5 арга хэмжээг үр дүнтэй, 3 арга хэмжээг “тодорхой үр дүнд хүрсэн” биелэлтийн дундаж 88.75 хувь гэж үнэлсэн нь мөн бодитой бус байна.

### 2.3. Мал хулгайлах гэмт хэрэг 2016-2019 онд 76-199 буюу 123 нэгжээр өсөж, хэргийн илрүүлэлт 46.2-37.1 хувь хүртэл буюу 9.1 хувиар, буурсан байна.

Хөтөлбөрийн 3 дугаар зорилтыг “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажилд техник технологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэн ашиглах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж байгаа цагдаагийн газар, алба хаагчдыг шаардлагатай техник бусад тусгай хэрэгслээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, хууль хяналтын байгууллагатай хамтран цаг үеийн нөхцөл байдалд уялдуулан хяналт шалгалтыг зохион байгуулах” гэж тодорхойлсон.

Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийн дунджийг 90.0 хувь гэж дүгнэсэн байна

Хүснэгт 7: Хөтөлбөрийн 2019 оны хэрэгжилт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлтийн хувь
3.1.	Аймгийн Цагдаагийн газрын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсэг, сумдын хэсгийн төлөөлөгч нарыг нэн шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, дэмжлэг үзүүлнэ.	100%
3.2.	Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх, хохирол нөхөн телүүлэлтийн хувь болон хэргийн шийдвэрлэлтийн хувийг ахиулна.	70%
3.3.	Олон үйлдэл, холбогдогчтой, бүлэг зохион байгуулалттай малын хулгайн гэмт хэргийг илрүүлэх шуурхай ажлын хэсэг томилон, цаг үеийн нөхцөл байдалд тулгуурлан иргэдэд мэдээлэх ажлыг зохион байгуулж, ээдрээ төвөгтэй хэргүүдийг шуурхай шийдвэрлэх талаар Цагдаа, Прокурор, Шүүхийн байгууллагатай хамтран ажиллах	100%
3.4.	Мал хулгайлах гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг судлан, арилгах, таслан зогсох, авах урьдчилан сэргийлэх Ерөнхий болон Тусгай арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх.	70%

3.5.	Хууль хяналтын байгууллагатай хамтран Нэгдсэн болон Хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулна.	100%
3.6.	Сумдын хэсгийн төлөөлөгчдийн үйл ажиллагаанд /гэмт хэрэг илрүүлэх, шалгах/ орон нутгийн захирагааны байгууллагаас дэмжлэг үзүүлэх	100%

Эх сурвалж: ХЭЗХ, МХГХТУСХ-ийн хэрэгжилтийн товчоо 2019.12.23

Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын 3.5 дахь “Хууль хяналтын байгууллагатай хамтран Нэгдсэн болон Хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулна” гэж тусгажээ.

Уг арга хэмжээний хэрэгжилтийг гаргахдаа “Хөтөлбөр хэрэгжих хугацаанд Хууль хяналтын байгууллагуудын хамтарсан Нэгдсэн арга хэмжээ 8, хэсэгчилсэн арга хэмжээ 32 зохион байгуулсан. Тухайлбал:

- Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт, хэрэгжүүлэх 57 арга хэмжээтэй баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- 2019 оны 10 сарын байдлаар аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ээс хамтран шинээр батлагдсан хуулиудыг таниулах, эрх зүйн сургалт сурталчилгааг зохион байгуулах сар тутмын сэдээчилсэн аяны жагсаалтыг батлан, аргачилсан зөвлөмжүүдийг бэлтгэж сум байгууллагуудад хүргүүлсэн.
- 2019 оны 1 сард “Үндсэн хууль” сэдвээр 14 хоногийн аян, 2 сард Авлигын болон НАНБХАСУС тухай, Төрийн албаны хууль, төрийн болон албаны нууцын тухай хуулиар 21 хоногийн, 3 сард үйлдвэрлэл үйлчилгээтэй холбоотой хуулиуд, 4 сард Байгаль орчныг хамгаалах тухай, Гамшигаас хамгаалах тухай, Цэргийн албаны тухай хуулиудыг сурталчлах аяныг 15 хоногоор, 5 сард Хүүхдийн эрх, Хүүхэд хамгаалал, Гэр булийн хүчирхийлэл, Архивын тухай, Иргэдээс төрийн байгууллагад гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль тогтоомж сурталчлах 15 хоногийн аян, 6 сард Боловсролын тухай хууль тогтоомж, 7 дугаар сард Захиргааны ерөнхий хууль тогтоомж сурталчлах 10 хоногийн аянуудыг тус тус нэгдсэн удирдамжтайгаар сум баг байгууллагууд, иргэдийн дунд зохион байгуулж нийт 10250 хүнийг хамруулсан.
- Сумдын ГХУСАЗСЗ-ийн гишүүдийг чадавхжуулах нэгдсэн сургалтыг “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх нь” сэдвээр зохион байгуулж 27 сумын салбар зөвлөлийн гишүүдийг бүрэн хамруулсан.
- Хөтөлбөр хэрэгжих хугацаанд “Төрийн цэргийн болон хуулийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд спортын цогцолбор тэмцээн” 2 удаа, “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээн 4 удаа, “Хуулиа дээдэль” тэмцээн-5 удаа, “Охид эмэгтэйчүүдийн бэлгийн хүчирхийллийн гинжийг тасалтъя” гэх мэт сургалт нөлөөллийн арга хэмжээнд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн төсөөөс хөтөлбөр хэрэгжих хугацаанд 27.480.000 төгрөгийг сургалт сурталчилгаа, тэмцээн уралдаан зохион байгуулахад зарцуулсан байна.” гэж тайлагнан биелэлт 100 хувь гэж дүгнэжээ.

Хууль хяналтын ямар байгууллагатай хамтарсан нь тодорхойгүй, хөтөлбөр хэрэгжсэн 4 жилд хийсэн арга хэмжээ юу эсвэл 2019 онд хийсэн арга хэмжээ юу гэдэг нь ялгагдахгүй, мал хулгайлах гэмт хэрэгтэй холбоотой хууль тогтоомжийн талаар хийсэн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ байхгүй байхад хэрэгжилтийг 100 хувь бүрэн хэрэгжсэн гэж дүгнэжээ.

Мөн уг зорилтын 3.2 дахь “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх, хохирол нөхөн төлүүлэлтийн хувь болон хэргийн шийдвэрлэлтийн хувийг ахиулна”

гэсэн заалтын хэрэгжилтийг "...Мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 23.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар, өмнөх сараас 1 хувиар тус тус өссөн байна..." гэж тайлагнаад хэрэгжилт 70 хувьтай гэж дүгнэсэн.

Хүснэгт 8: Мал хулгайлах гэмт хэргийн тоо, илрүүлэлт, шийдвэрлэлт

№	Мал хулгайлах гэмт хэргийн тоо, илрүүлэлт, шийдвэрлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он
1	Бүх хэрэг	76	115	114	199
2	Хэрэг бүртгэлтийн хэрэг	65	100	94	178
3	Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэг	30	39	36	66
4	Илрүүлэлтийн хувь	46.2%	39.0%	38.3%	37.1%

Эх сурвалж: Цагдаагийн газар, хэргийн хөдөлгөөний судалгаа

Гэтэл мал хулгайлах гэмт хэрэг 2016-2019 онд 76-199 буюу 123 нэгжээр өсөж, хэргийн илрүүлэлт 46.2-37.1 хувь хүртэл буюу 9.1 хувиар, 2019 онд өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар буурсан байхад өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар өссөн гэж хэрэгжилтийг гаргасан байна. Түүнчлэн хөтөлбөр хэрэгжих хугацаанд хэдэн иргэнд хичнээн төгрөгийн хохирол учирсан болон тухайн хохирлыг хэрхэн барагдуулсан талаар судалгаа, тооцоололгүй байхад холбогдо заалтын хэрэгжилтийг 70 хувь гэж үнэлсэн нь бодит байдалтай нийцээгүй байна.

Түүнчлэн Төв аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2016-2019 онд мал хулгайлах гэмт хэрэгт нийт 77 хэрэгт 191 хүн ял шийтгүүлсэн байна.

Хүснэгт 9: МХГХэрэгт шүүхээс оногдуулсан ялын судалгаа

№	Он	Хэр-гийн тоо / ял шийтгүүлсэн хүний тоо	Оногдуулсан ялын төрөл					Гэмт хэргийн улмаас учирсан хохирол /сая.төг/	Улсын орлогод хураасан хөрөнгө /сая.төг/
			Нийтэд тустай ажил хийлгэх /Зорчих эрхийг хязгаарлах	Барив -члах	Хорих 6 сар - 5 жил	2-8 жил	5-12 жил		
1	2016	18/35	2	5	28			24	6.9
2	2017	20/39	1	6	5		6	21	222.7
3	2018	12/26	5	-	6	-	-	15	51.1
4	2019	27/46	12	-	20	2	-	12	159.9

Эх сурвалж: Төв аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Эрүүгийн хэргийн мэдээ 2016-2019 он

Аймгийн ИТХТ-ийн 2020 оны 22 дугаар тогтоолоор хөтөлбөрийн хэрэгжилтийг 3 дугаар зорилтын хүрээнд 4 арга хэмжээг “үр дүнтэй”, 2 арга хэмжээг “тодорхой үр дүнд хүрсэн” гэж, 3.5-д хамааралгүй хэрэгжилт тусгасан, 3.2 дахь заалт нь бүрэн хэрэгжээгүй байхад биелэлтийн дундаж 90.0 хувь гэж үнэлсэн нь мөн бодитой бус байна.

**Хөтөлбөрийн хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр хяналт  
шинжилгээ-үнэлгээ хийхээр төлөвлөсөн ч хэрэгжүүлж  
ажиллаагүй байна.**

**3.1. Хөтөлбөрийн 9.1-д заасан хугацаанд буюу хагас, бүтэн жилээр  
хяналт шинжилгээ үнэлгээ хийнэ гэсэн заалт хэрэгжээгүй байна.**

Хөтөлбөрийн 9.1-д Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтэнд аймгийн ЗДТГ-ын ХЗХ-ээс холбогдох байгууллагуудтай хамтран хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ үнэлгээ хийнэ гэж заажээ.

Хөтөлбөр хэрэгжих хугацаанд аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсээс нэг удаа буюу 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдөр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт гаргасан байна. Тус хөтөлбөрийн 3 зорилт 20 арга хэмжээнд ХШҮ хийхэд 70 хувьтай 14, 40 хувьтай 6, дунджаар 61.0 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэжээ.

Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувьтай дүгнэгдсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх талаар үр дүнтэй ажил зохион байгуулах, малын хулгайтай холбоотой үнэн зөв мэдээлэл өгсөн иргэдийг урамшуулах, малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, урамшуулах, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх нэгдсэн арга хэмжээ, аянг цаг хугацааны үечлэлтэй зохион байгуулж үр дүнд хүргэх, мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 2012-2015 оны дунджаар 54.1 хувьтай байсан бол 2016 онд 46.2 хувь болж буурсанд дүгнэлт хийж, илрүүлэлтийг нэмэгдүүлэх, цаашид бодлогын баримт бичиг боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн шалгуур үзүүлэлтийг ХШҮ хийхүйцээр тодорхойлж, суурь түвшинтэй харьцуулан хүрэх түвшинг он тус бүрээр гаргаж хэвшиг зэрэг 6 зөвлөмжийг өгчээ.

Хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдээд илэрсэн асуудлуудад дүгнэлт хийсэн боловч өгсөн зөвлөмж нь хэн хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй, зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар албан ёсны баримт бичиг байхгүй байна. Тухайлбал: Аймгийн ИТХТ-ийн 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 22 тоот тогтоолоор “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө 2020-2022”-г батлахдаа шалгуур үзүүлэлт тавиагүй байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох баримтаас үзэхэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсээс холбогдох байгууллагуудтай хамтран хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ үнэлгээ хийнэ гэсэн заалт хэрэгжээгүй, хөтөлбөр хэрэгжсэн 4 жилийн хугацаанд 1 л удаа хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

**3.2. Аймгийн ГХУСАЗС3, ЗДТГ-ын ХЭЗХэлтсийн хөтөлбөрийн  
хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байсан байна.**

Хөтөлбөрийн 9.2-т сумдын ГХУСАЗС3, холбогдох агентлагууд хөтөлбөрийн биелэлтийг аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэст хагас, бүтэн жилээр гаргаж ирүүлэхээр батлагдсан. Гэвч сумдын ГХУСАЗС3, холбогдох агентлагууд хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гаргаж ирүүлдэггүй, ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс аймгийн хэмжээнд хэрэгжилтийг хагас бүтэн жилээр нэгтгэж гаргаагүй байна.

Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас үзэхэд, сумдаас хэрэгжилтийг янз бүрээр гаргадаг, зарим сумд аймгийн хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу, зарим нь сум орон нутгийн онцлогт тохируулан өөрсдийн боловсруулсан

хөтөлбөрийн хэрэгжилтийг, зарим сумд огт ирүүлдэггүй байна. Жишээ нь: 2020 онд хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнүүлэхэд аймгийн хэмжээний нэгдсэн тоог гаргахын тулд сумдаас бүрэн материал ирээгүй тул аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийн дэвтрээс 2019, 2020 онд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний тайланг татан авч нэгтгэсэн байна.

Аймгийн 27 сумын хэмжээнд хөтөлбөр, төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажилласныг нотлох баримт материал зарим сумдад дутуу буюу байхгүй, хариуцсан хэлтэс нь хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргахдаа тухайн арга хэмжээнд хамааралгүй зарим зүйлсийг тусгасан, холбогдох баримтыг 27 sumaас бүрэн авч нэгтгэдэггүй, бичиг баримтыг архивладаггүй тавьдаггүй зэргээс үзэхэд аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ээс тавих хяналт хангалтгүй байсан байна.

Хөтөлбөрийн хэрэгжсэн 4 жилд Аймгийн ИТХТ-ийн хурлаар хөтөлбөрийн хэрэгжилтийг 3 удаа, аймгийн ГХУСАЗС3-ын хурлаар 1 удаа хэлэлцэж тодорхой үүрэг чиглэл өгч байсан байна. Тухайлбал:

- ИТХТ-ийн 2016 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны 06 дугаар тэмдэглэлээр 8 заалт бүхий үүрэг, чиглэл,
- ИТХТ-ийн 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 76 дугаар тогтоолоор аймаг, сумдын Засаг даргад 11 үүрэг чиглэл,
- ИТХТ-ийн 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга болон ГХУСАЗ сумын зөвлөлийн дарга нарт 9 үүрэг чиглэл,
- Аймгийн ГХУСАЗС3-ийн 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн “Мал хулгайлах гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, дэмжлэг үзүүлэх тухай” 14 дүгээр тогтоолоор аймгийн Цагдаагийн газар, сумдын ГХУСАЗС3, дэд зөвлөл, аймгийн Засаг дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, аймгийн ГХУСАЗС3-ийн нарийн бичгийн дарга нарт тодорхой үүрэг чиглэл өгөгдсөн байна.

ИТХТ, Аймгийн ГХУСАЗС3-ийн тогтоолуудаар өгөгдсөн үүрэг даалгаварыг хэрхэн хэрэгжүүлж, тогтоолын биелэлтийг гаргаж ирүүлсэн, хариу мэдэгдэж ажиллассан баримт материал аудитын явцад гаргаж ирүүлээгүй.

Эндээс үзэхэд, аймгийн ГХУСАЗС3, ЗДТГ-ын ХЭЗХ-ийн хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байсан байна.

### **3.3. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээнүүд бүрэн хэрэгжсэн гэж үзэх боломжгүй байна.**

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь анх батлагдаадаа утга санаа давхацсан 1 өгүүлбэрт олон арга хэмжээг багтаасан, шалгуур үзүүлэлт нь тодорхойгүй, хэрэгжилтийг тодорхой гаргахад хүндрэлтэй баримт бичиг болсон байна.

Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ээс 2019 оны 12 дугаар сарын 23-нд хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргаж, аймгийн ИТХТ-ийн 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 22 тоот тогтоолоор хөтөлбөрийн хэрэгжилтийг 91 хувь “Үр дүнтэй” гэж батлуулсан байна. Хөтөлбөрийн хүрээнд 3 зорилт 20 арга хэмжээний хэрэгжилтийг тооцоходоо 14 арга хэмжээг 100 хувь “Үр дүнтэй” 6 арга хэмжээг 70 хувь “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэжээ.

Аудитаар 100 хувь буюу “Үр дүнтэй” гэж үнэлэгдсэн 14 арга хэмжээнээс 12, 70 хувь “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн 6 арга хэмжээнээс 4 арга хэмжээг хэрэгжүүлж зарим үр дүн гарсан гэж үзсэн.

Харин хөтөлбөрийн дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, үр дүн гарсан гэдэг нь холбогдох баримтаар нотлогдохгүй байна гэж үзлээ. Үүнд:

- 7.1.2 дахь “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр аймаг, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулна”,
- 7.2.2 дахь “Мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрсдийн эзэмшилд байгаа малаа бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүрэн хамруулахад Төрийн байгууллагатай хамтран ажиллах” гэх заалт болон 70 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн
- 7.2.3 дахь “Мал бүхий иргэд малдаа им тэмдэг, зүсмийн бүртгэлд оруулах бод малаа улсын хэмжээний индексжүүлэлт, им тамга тэмдгийн сүлжээнд бүрэн хамруулсан байх”,
- 7.3.2 дахь “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх, хохирол нөхөн төлүүлэлтийн хувь болон хэргийн шийдвэрлэлтийн хувийг ахиулна” гэх заалтын үнэлгээ нь бодитой бус хэрэгжилтийг хэтрүүлэн үнэлсэн байна гэж үзлээ

Хөтөлбөрийн 8 дугаар зүйлд хүрэх үр дүнг “Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны, хууль хяналтын, олон нийтийн байгууллагууд, аж ахуйн нэгж, ард иргэдийн санал, санаачилгыг нэмэгдүүлэн олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн олон нийтийн оролцоог хангаж, мал хулгайлах гэмт хэргийн тоог бууруулж, хэргийн илрүүлэлтийг ахиулж, учирсан хохирлыг багасгаж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд иргэд, байгууллагын ажиллах нөхцөл боломжийг сайжруулсан байна.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцдэг цагдаагийн албаны мэдээллийн техник, холбоо, унаагаар зохих түвшинд хангаж, ажиллах нөхцөл бололцоог дээшлүүлсэн байна байна. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эрх зүйн мэдлэг дээшилж, өмч хөрөнгийн хамгаалалтаа сайжруулан хулгайд өртөхгүй байх арга хэмжээг хэвшүүлсэн байна” гэж тодорхойлсон.

Мал хулгайлах гэмт хэрэг нь нийгэм, эдийн засгийн байдал, хууль эрх зүйн орчин зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай хэдий ч хөтөлбөр хэрэгжсэн жилүүдийн цагдаагийн газрын статистик мэдээ судалгаанаас үзэхэд гэмт хэргийн гаралт өссөн, илрүүлэлтийн хувь буурсан байна /Хүснэгт 9/. Эндээс үзэхэд хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн гэж үзэхэд учир дутагдалтай байна.

## ДҮГНЭЛТ.

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.**


1. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь утга санаа давхацсан 1 өгүүлбэрт олон арга хэмжээг багтаасан, шалгуур үзүүлэлт нь тодорхойгүй, хэрэгжилтийг тодорхой гаргахад хүндрэлтэй баримт бичиг болсон байна.
2. Хөтөлбөрийн 100 хувь буюу “Үр дүнтэй” гэж үнэлэгдсэн 12, “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн 4 арга хэмжээ, нийт 16 арга хэмжээний хүрээнд тодорхой ажлууд хийгдсэн байна. Харин 100 хувь хэрэгжсэн гэх 2 арга хэмжээ болон 70 хувь хэрэгжсэн гэх 2 арга хэмжээ, нийт 4 арга хэмжээний хэрэгжилтийг бодитой бус дүгнэжээ.
3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг 27 сумдын ГХУСАЗСЗ-с бүрэн авч, нэгтгэдэггүй, зарим сумд хөтөлбөрийн хүрээнд жилийн төлөвлөгөө боловсруулдаггүй, хэрэгжилтийг гарагддаггүй байна.
4. Зарим сумын ИТХТ-ийн хуралдаанаар хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэдэггүй, мөн боловсруулсан төлөвлөгөө, хэрэгжилт зэрэг баримт бичгийг архивладаггүй зөрчил байна.
5. Хөтөлбөрийн явцад хагас бүтэн жилээр хяналт шинжилгээ үнэлгээ хийхээр батлагдсан боловч хөтөлбөр хэрэгжсэн 4 жилд 1 удаа л хийгдсэн байна.
6. Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих аймгийн ГХУСАЗСЗ, ЗДТГ-ын ХЭЗХ-ийн хяналт хангартгүй байна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн аймгийн ГХУСАЗСЗ-ийн дарга Ц.Энхбат, Хууль эрх зүйн хэлтсийн дарга Ц.Ариунбаяр нарт зөвлөх нь:

1. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө /2020-2022 он/-ний хэрэгжилтийг аймгийн хэмжээнд жигд зохион байгуулж, биелэлтийг хангаж ажиллах.
2. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө /2020-2022 он/, хэрэгжилт, зэрэг холбогдох баримт бичгийг архив бичиг хэргийн стандартын дагуу архивлан хадгалах, хариуцсан мэргэжилтэн солигдсон нөхцөлд баримт, материалыг хулээлцүүлж, тэмдэглэл үйлдэн албажуулах.
3. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-д заасныг хэрэгжүүлж ажиллах.
4. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө /2020-2022 он/-ний хэрэгжилтийг бодитой үнэлж, дүгнэх.

### Тайлан хянасан:



## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ТОВ АЙМГИИН  
ИРГЭДИЙН ТОЛООЛОГЧДИЙН  
ХҮРЭНЫ ТЭРГҮҮЛЭГЧИД

41111, Төв аймаг, Зүйнмэл сум, Гаутар баг  
Утас: 7027-1008, Факс: (076) 7027-2154  
Имэйл: [tovaimgiin\\_irgeediyin@mail.ru](mailto:tovaimgiin_irgeediyin@mail.ru), Веб сайт: [www.tovaimgiin.com](http://www.tovaimgiin.com)

2020.07.16 № 209  
төслийн датын № 01/345

### ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ ТАНАА

"Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх,  
урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилт"-энд  
хийсэн нийцлийн аудитын тайлангийн төслийг  
ируулсантай танилцлаа.

Аливаа тамга тэмдэггүй тайлангийн теселд  
өгөх тусгайсан санал байхгүй бөгөөд нийцлийн  
аудитын тайланг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
07 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар  
хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргах тул уг  
асуудлыг хэлэлцүүлэх бэлтгэл, зохион байгуулалтыг  
хангаж ажиллана уу.



My doc:- /2020on /A5 toot



239

МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

жаро оны 07 сарын 20 одөр

Дугаар 114

Зуунмод

Г

Т

Нийцлийн аудитын тайлан  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.2, Улсын Ерөнхий аудиторын 2018 оны A/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны A/146 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ын 13.8 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ Нь:

1. Аймгийн ИТХ-ын захиалгаар Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилт /2016-2019/-нд хийсэн нийцлийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг баталгаажуулсугай.

2. Нийцлийн аудитаар өгөгдсөн дүгнэлт, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор Г.Сугармаа нарт даалгасугай.

3. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу тодорхой арга хэмжээ авч хэрэгжилтийг 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ГХУСАЗС3-ийн дарга Ц.Энхбат, Хууль эрх зүйн хэлтсийн дарга Ц.Ариунбаяр нарт зөвлөсүгэй.



D 2020 /2020 он/ TUSHAAL 2020

19010064